



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/636

Хэрлэн сум

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд
бүртгэлтэй хүүхдүүдэд зориулсан
“Хүүхэд бид ирээдүйн толь” вакум сургалтад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.4.9.1 дэх заалт, Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.9 дэх заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд вакум сургалтыг зохион байгуулах зардалд 2,400,000 (хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхэд ээлтэй орон нутаг болно зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 12-ны өдрийн
12/13 дугаар захирамжийн хавсралт

“ХҮҮХЭД БИД ИРЭЭДҮЙН ТОЛЬ”
СЭДЭВТ СУРГАЛТАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цайны материал	ш	50	10,000	500,000
2	Бэлэг	ш	50	20,000	1,000,000
3	Дэвтэр	ш	50	5,000	250,000
4	Бал	ш	50	2,000	100,000
5	Бичгийн цаас	ш	3	20,000	60,000
6	Заалны түрээс	цаг	8	50,000	400,000
7	Плипчарт цаас	ш	2	40,000	80,000
8	Өнгийн харандаа	ш	5	2,000	10,000
	Нийт зардал				2.400.000